

СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ

**НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД**

**а/ Сумын ИТХ-ын ажлын чиглэлээр:** Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас зохион байгуулан явуулдаг байгууллагуудын хамтын үйл ажиллагааг сайжруулах, мэдээ мэдээлэлээ ил тод шуурхай солилцох ажлын хүрээнд сар бүрийн ажлын эхний өдөр “УДИРДАХ АЖИЛТНЫ МЭДЭЭЛЛИЙН ЦАГ”-ыг 2023 оын 3 сарын 2 ны өдөр хуралдаж сумын нийт албан байгууллагуудын дарга эрхлэгч нартай уулзан мэдээлэл солилцон одоогийн цаг үеийн байдал болоод ирэх сард хийхээр төлөвлөж байгаа ажлуудын талаар санал солилцон ажилласан.

2023 оны 03 сарын 9-ны өдөр “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН САНАЛ АВАХ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ АЖИЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ” сургалтанд ИТХ-ын мэргэжилтэн цахимаар оролцсон.

2023 оны 3 сарын 17-ны өдөр УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН зохион байгуулагдаж ИТХ-ын даргатай байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон мэргэжилтэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллав.

**б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:**

Удирдах ажилтны зөвлөгөөнийг 2023 оны 03 дугаар сарын 17 ны 08:00 цагаас 16:00 цагийн хооронд амжилттай зохион байгууллаа. Зөвлөгөөнд ИТХ-ын дарга, Засаг дарга, Төсөвт байгууллагуудын удирдлагууд, байгууллагын бичиг хэргийн ажилтнууд, багийн Засаг дарга, ЗДТГ-ын мэргэжилтнүүд 2022 оны ажлын үр дүн, 2023 оны ажлын төлөвлөгөөгөө танилцуулж оролцлоо. Нийт 35 албан хаагч хамрагдлаа. Зөвлөгөөний дараагаар ИТХ-ын дарга ИТХ-ын нарийн бичигтэй, Засаг дарга Тамгын газрын дарга, Санхүү албаны дарга, байгууллагын дарга, 1,2,3,4 дугаар багийн засаг дарга нартай, Тамгын газрын дарга тамгын газрын 3 мэргэжилтэнтэй тус тус гэрээ байгууллаа. Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар багийн засаг дарга нартай уулзаж хаваржилт, төл бойжилтын талаар ярилцлаа.

Шатрын дугуйлан 3 сарын 17 ны өдөр нээлтээ хийж бага болон дунд ангийн нийт 25 хүүхэд 3 ээлжээр өдөр болгон хичээллэж байна. Нээлтийн арга хэмжээнд "ОЮУНЛАГ" клубын багш тамирчид ирж оролцсон ба нээлтэд зориулсан шатрын тэмцээн зохион байгуулагдлаа.

Байгаль цаг уурын аюултай үзэгдэл болохтой холбоотой сумын онцгой комисс мэргэжилийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж, 23 ны өдөр сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг нэг өдрийн турш хааж гэмтэл ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллав.

Алдарт эхийн 1,2 дугаар одон авах эхчүүдийн материалыг хүлээн авч аймгийн ТЗУ хэлтэст хүргүүлж ажиллав.

ХНУМС-д төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон цалингийн өөрчлөлт, төрийн захиргааны албан хаагчийн ангилал зэрэглэлийг шинэчлэн орууллаа.

Энэ сарын 14-17 ны өдрүүдэд зохион байгуулагдсан төрийн албаны ерөнхий шалгалтад нийт халзан сумаас 8 иргэн хамрагдсанаас 4 иргэн тэнцэж тусгай шалгалтад бүртгүүлээд байна.

### **ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:**

3 дугаар сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 59.2 сая төгрөг авч орон нутгийн төсвийн байгууллагуудад 121.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 6 төсөвт байгууллага, 1 ОНӨҮГ, 2 тусгай сан, эмийн эргэлтийн сан, төрийн сан гэсэн 11 байгууллага гаргаж хуулийн хугацаанд холбогдох байгууллагад шалгуулан, дүгнэлт авч нэгтгүүллээ.

Сумын санхүү алба нь аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй байгуулсан “2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ”-ний үүргээ хангалттай сайн биелүүлж, нийлбэр оноогоор 2 дугаар байранд орсон байна.

### **ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:**

2023 оны 01 сарын 01 ний өдрөөс хэрэгжиж байгаа Зөвшөөрлийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 488, 491, 490, 487 дугаар тогтоолуудыг тус тус танилцуулан ажиллалаа.

Алсын хараа 2050 цахим сургалт нийт 53 төрийн албан хаагч хамрагдахаас 49 албан хаагч хамрагдаж сертификатаа авсан байна.

Сүхбаатар аймгийн ОБГ-аас зохион байгуулсан Гамшгаас хамгаалах ажил хариуцсан мэргэжилтэнүүдийн сургалтанд онлойнаар хамрагдан гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах, галын аюулгүй байдлын тухай хуулиар сургалт хүлээн авлаа

### **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

**Ерөнхий боловсролын сургууль:** 3-р сарын 6-ны өдөр сумын соёлын төвтэй хамтран “Уран жиргээ”-2023 уралдааны 1-н давааг амжилттай зохион байгуулж, ангилал тус бүрээс шалгарсан сурагчдыг дараагийн шатанд нь амжилттай оролцуулсан.

3-р сарын 18-ны өдөр Баруун-Урт хотод зохион байгуулагдсан төрөлжсөн олимпиадын 2-н даваанд 6 багш 4 сурагч амжилттай оролцож дүрслэх урлаг технологийн хичээлээр багш Ц.Мөнхболд Тэргүүн байр, орос хэлний хичээлээр Л.Дэлгэрмаа 2-р байр мөнгөн медаль, Газарзүйн хичээлээр 9-р ангийн төрөлд 2-р

байр мөнгөн медаль, түүхийн хичээлээр багш Ц.Оюунсүвд – 5-р байр, математикийн багш О.Адилбиш 5-р байр тус тус эзэлсэн амжилттай байна.

**Соёлын чиглэлээр:** Сүхбаатар аймгийн нийтийн номын сангийн Аргазүйч Чандмань, Ном зүйч Нарангэрэл нартай хамтран номын сангийн сан хөмрөгт байгаа номнуудыг ангилах, цэгцлэх хадгалалт хамгаалалтыг сайжруулах, мөн LIBU4 программд номыг хэрхэн зөв бүртгэх талаар номын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг зөв бүртгэн баримтжуулах ажлаар зөвлөгөө мэдээлэл, ажлын туршлагааас нь хуваалцсан үр дүнтэй ажлыг зохион байгуулан ажиллалаа.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамрагдах иргэдийн нэрсийг гарган өрх хүн амаа бүлэглэх ажил хийгдэж байна

Мөн өвөлжилтийн мэдээг 14 хоног тутам ЭМГ мэдээлж ажиллалаа. Халдварт өвчин байхгүй

#### **Хөдөлмөр халамжийн чиглэлээр:**

Ахмад настны хуулиар ганц бие асран хамгаалах үр хүүхэдгүй Д. Навчааг түлээ нүүрсний хөнгөлөлтөнд хамруулах зөвлөл 100% саналаар дэмжсэн.

Байнгын асаргааны сунгалт 2 ахмад настан 2022 оны 10 сард 96 ахмад ахмадын хүндэтгэлд байсан. Шилжсэн 4 ахмад, Ахмадын хорооны дарга, нарийн бичигтэй хамтран 1 ахмад настаныг төрийн болон төрийн бус байгууллагад харъяалалтай болгосон.

Насны хишигт 65 нас хүрсэн 9 ахмад настанг бүртгээд байна.

Зээлийн эргэн төлөлт “Авлага баталгаажуулжт” хийж зээлдэгч өнгөрсөн оны эргэн төлөлттэй 7 иргэнтэй холбогдож зээлийн төлөлт гарын үсэг зуруулсан.

**Жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хөгжүүлэх сангийн чиглэлээр:** 2023 оны 03-р сарын 25-ны байдлаар нийт 11 зээлдэгч байгаагаас 2022 оны 01 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 9 хүнээс 5,411,271 мянган төгрөгний орлого хоршоо хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Сумын хүнсний гол нэрийн нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг Даваа гарагт аймгийн ХХААГазарт мэдээлж байна.

Монгол Улсын Засгийн Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай” А/37 дугаар тушаалын дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2023 онд олгох хөнгөлөлттэй зээлийн төсөл хүлээн

авах үйл ажиллагаа 2023.02.09-ний өдрөөс эхлэн цахим системээр дамжуулан 30 хоногийн хугацаанд цахимаар хүлээн авч 3 сарын 10 ны өдөр хаагдлаа.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** Зүй бусын хорогдолын мэдээ болон өвөлжилтийн дүн мэдээг долоо хоногийн Лхавга гарагт ХХААГазарт явуулан ажиллаж байна.

**Мал эмнэлэгийн чиглэлээр:** Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 01 албан даалгаврын хүрээнд ариутгал халдваргүйтгэд сэг зэм устгах нэгдсэн төлөвлөгөөг гаргаж батлуулаад байна.

Эрт илрүүлэг, гоц халдварт өвчний тандалт судалгааг багийн иргэдээс түүврийн аргаар авах ажлыг эхлүүлсэн.

Сумын төвийн үнсний голын зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цуглуулах ариутгал халдваргүйтгэл хийх ажлын хэсгийг байгуулах сумын засаг даргын А/29 тоот захирамжийг гаргасан.

Орон нутгийн шөвөг яр, дхх-ийн вакцины хуваарлалтыг хийгээд байна .

**Байгаль орчны чиглэлээр:** Онгон , Уулбаян, Баруун-Урт сумдаас отроор ирж өвөлжсөн айл өрхүүдэд нутаг чөлөөлөх мэдэгдлийг өгч нутаг чөлөөлөв. Үүнд 6 өрх хамрагдан нутаг чөлөөлсөн.

Газрын тосны хоолой тавих компаний байгаль орчны мэргэжилтэн Дэлгэржаргалтай 99358589 тоот утсаар ярьж газрын тосны хоолой тавих ажилд зориулан гаргасан зам барилгын ажил дуусаагүй байхад Цайрт минераль ХХК-ны хүдэр тээвэрлэгч том оврын авто машин явж осол аваар гаргаж байгаа талаар сануулж уг замаар зорчсон том оврын авто машинуудын дугаарыг авч Цайрт минераль ХХК-нд албан шаардлага хүргүүлэв.

2023 оны 03 сарын 14-нд болсон хүчтэй цасан шуурганаар алга болсон хүний эрэлд эрэн хайх бүлгүүдийг зохион байгуулж эрэлийг 3 хоног үргэлжлүүлсэн үүнд 8 бүлэг 8 авто машин 42 иргэн хамрагдав.

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:

М.БАТБЭХ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ  
Д.ДАЙРИЙМАА

